

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/185/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор хот 2022 оны 02 дугаар сар</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 80112188 Цахим хаяг: myangnbuum@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Албан шаардлага	16
4.3 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт
МЭЕГ	Мал эмнэлгийн Ерөнхий газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2022.02.16 № 2/04

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A large, stylized handwritten signature in black ink, written over a red rectangular stamp. The signature is slanted and extends across the stamp and the text to its right.

Б.МӨНХБАТ



**Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>162,178,155.59</u>	<u>159,787,317.02</u>
33	АВЛАГА	-	1,100,000.00
335	Бусад авлага	-	1,100,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	1,100,000.00
34	УРЬДЧИЛГАА	-	7,200,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	7,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	162,178,155.59	151,487,317.02
351	Түүхий эд материал	101,290,585.59	112,453,862.55
35110	Тусгай зориулалттай материал	96,748,985.59	96,231,545.12
35130	Эм боох материал	4,541,600.00	16,222,317.43
354	Хангамжийн материал	59,902,570.00	38,048,454.47
35410	Бичиг хэргийн материал	7,107,375.00	9,424,975.00
35420	Аж ахуйн материал	46,842,445.00	23,674,717.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	860,000.00
35440	Түлш, шатах тослох материал	5,277,690.00	1,627,172.47
35470	Бусад хангамжийн материал	675,060.00	2,461,590.00
35600	Мал амьтад	985,000.00	985,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>595,689,702.84</u>	<u>1,292,101,605.49</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	595,689,702.84	1,292,101,605.49
392	Биет хөрөнгө	593,820,952.78	1,290,802,855.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	64,691,600.00	64,691,600.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(17,491,553.04)	(26,237,329.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	266,259,629.67	616,913,629.67
39204	Хуримтлагдсан элэгдэл	(133,650,567.90)	(174,954,523.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	475,500,749.68	969,349,657.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	(102,621,335.37)	(212,781,808.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,262,000.00	68,452,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,129,570.26)	(14,631,070.46)
393	Биет бус хөрөнгө	1,868,750.06	1,298,750.06
39301	Програм хангамж	2,280,000.00	2,280,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(411,249.94)	(981,249.94)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>757,867,858.43</u>	<u>1,451,888,922.51</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>60,662.00</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	60,662.00	-
413	Өглөг	60,662.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	60,662.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>757,807,196.43</u>	<u>1,451,888,922.51</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	757,807,196.43	1,451,888,922.51
512	Хуримтлагдсан үр дүн	703,129,546.36	1,397,211,272.43
51210	Өмнөх үеийн үр дүн	703,129,546.36	703,129,546.36
51220	Тайлант үеийн үр дүн	-	694,081,726.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	54,677,650.07	54,677,650.07
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>757,867,858.43</u>	<u>1,451,888,922.51</u>

**Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,950,322,706.82	3,491,767,914.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	399,539,816.82	1,695,874,434.83
120	Нийтлэг татварын бус орлого	399,539,816.82	1,695,874,434.83
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	399,539,816.82	1,695,874,434.83
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,080,100.00	2,297,100.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	397,459,716.82	1,693,577,334.83
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,550,782,890.00	1,795,893,480.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	708,493,100.00	894,806,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	708,493,100.00	894,806,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	842,289,790.00	901,086,680.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	714,193,000.00	700,193,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	128,096,790.00	200,893,680.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,897,821,356.37	2,797,686,188.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,897,821,356.37	2,797,686,188.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,866,946,915.13	2,785,365,048.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	100,828,800.00	567,744,232.00
210101	Үндсэн цалин	75,511,500.00	443,782,435.00
210102	Нэмэгдэл	21,946,300.00	59,860,623.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,371,000.00	49,177,919.00
210104	Урамшуулал	-	14,923,255.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,611,900.00	78,252,444.00
210201	Тэтгэврийн даатгал	9,578,700.00	55,048,544.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,008,300.00	5,801,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	806,600.00	4,640,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	201,700.00	1,160,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,016,600.00	11,601,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,717,891.00	26,200,012.00
210301	Гэрэл, цахилгаан	1,817,459.00	1,586,900.00
210302	Түлш, халаалт	20,650,000.00	21,600,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,250,432.00	3,013,112.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,249,413.00	66,655,549.53
210401	Бичиг хэрэг	4,978,856.00	4,394,050.00
210402	Тээвэр, шатахуун	20,859,498.00	29,084,571.53
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,853,159.00	4,200,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	266,800.00	219,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,122,100.00	2,747,000.00
210408	Бараа материал акталсны зардал	1,169,000.00	26,010,028.00
2105	Нормативт зардал	415,885,376.60	980,577,675.47
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	415,885,376.60	980,577,675.47
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,267,500.00	5,299,500.00
210604	Урсгал засвар	4,267,500.00	5,299,500.00
2107	Томилолт, зочны зардал	-	2,300,000.00
210702	Дотоод албан томилолт	-	2,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,150,245,384.00	891,053,930.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,148,219,026.00	884,839,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	102,500.00	82,000.00

**Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210803	Даатгалын үйлчилгээ	750,000.00	720,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	376,780.00	400,080.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	134,178.00	856,450.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	3,600,000.00
210807	Газрын төлбөр	262,900.00	556,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	124,140,650.53	167,281,705.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	156,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	123,984,650.53	167,281,705.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,874,441.24	12,321,140.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,817,393.00	1,382,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,517,393.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.00	1,382,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,057,048.24	10,939,140.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,057,048.24	10,939,140.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>52,501,350.45</u>	<u>694,081,726.07</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>52,501,350.45</u>	<u>694,081,726.07</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	54,677,650.07	650,628,195.91	705,305,845.98
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	54,677,650.07	650,628,195.91	705,305,845.98
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	54,677,650.07	703,129,546.36	757,807,196.43
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	54,677,650.07	703,129,546.36	757,807,196.43
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	54,677,650.07	703,129,546.36	757,807,196.43
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	54,677,650.07	703,129,546.36	757,807,196.43
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	694,081,726.07	694,081,726.07
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	54,677,650.07	1,397,211,272.43	1,451,888,922.50

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,552,862,990.00</u>	<u>1,798,190,580.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,080,100.00	2,297,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,080,100.00	2,297,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,080,100.00	2,297,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,080,100.00	2,297,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,550,782,890.00	1,795,893,480.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	708,493,100.00	894,806,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	708,493,100.00	894,806,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	842,289,790.00	901,086,680.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	714,193,000.00	700,193,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	128,096,790.00	200,893,680.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,543,120,990.00</u>	<u>1,798,190,580.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,543,120,990.00	1,798,190,580.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,511,844,048.76	1,785,869,439.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	100,828,800.00	567,744,238.00
210101	Үндсэн цалин	75,511,500.00	443,782,435.00
210102	Нэмэгдэл	21,946,300.00	59,860,618.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,371,000.00	49,177,930.00
210104	Урамшуулал	-	14,923,255.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,611,900.00	78,313,100.00
210201	Тэтгэврийн даатгал	9,578,700.00	55,109,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,008,300.00	5,801,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	806,600.00	4,640,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	201,700.00	1,160,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,016,600.00	11,601,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,717,891.00	26,200,012.00
210301	Гэрэл, цахилгаан	1,817,459.00	1,586,900.00
210302	Түлш, халаалт	20,650,000.00	21,600,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,250,432.00	3,013,112.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,516,959.00	27,292,250.00
210401	Бичиг хэрэг	6,158,100.00	5,878,150.00
210402	Тээвэр, шатахуун	20,565,900.00	13,558,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,545,659.00	4,800,900.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	266,800.00	219,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	980,500.00	2,835,300.00
2105	Нормативт зардал	8,501,615.60	1,798,900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,671,915.60	1,798,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	829,700.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,613,400.00	4,956,800.00

**Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,194,750.00	-
210604	Урсгал засвар	6,418,650.00	4,956,800.00
2107	Томилолт, зочны зардал	-	2,300,000.00
210702	Дотоод албан томилолт	-	2,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,317,053,483.16	1,077,264,139.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,315,027,125.16	1,063,849,509.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	102,500.00	82,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	750,000.00	720,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	376,780.00	400,080.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	134,178.00	856,450.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	262,900.00	556,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,276,941.24	12,321,140.40
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,219,893.00	1,382,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,517,393.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,702,500.00	1,382,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,057,048.24	10,939,140.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,057,048.24	10,939,140.40
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>9,742,000.00</u>	≡
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,742,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,742,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	9,742,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,742,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(9,742,000.00)</u>	≡
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	894,806,800.00	886,340,023.20	8,466,776.80	99.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	894,806,800.00	886,340,023.20	8,466,776.80	99.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	893,421,600.00	884,958,023.20	8,463,576.80	99.05
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	576,097,000.00	567,744,238.00	8,352,762.00	98.55
210101	Үндсэн цалин	447,067,100.00	443,782,435.00	3,284,665.00	99.27
210102	Нэмэгдэл	60,590,400.00	59,860,618.00	729,782.00	98.80

**Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,282,900.00	49,177,930.00	104,970.00	99.79
210104	Урамшуулал	19,156,600.00	14,923,255.00	4,233,345.00	77.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,313,100.00	78,313,100.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	55,109,200.00	55,109,200.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,801,000.00	5,801,000.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,640,800.00	4,640,800.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,160,200.00	1,160,200.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,601,900.00	11,601,900.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,231,600.00	26,200,012.00	31,588.00	99.88
210301	Гэрэл, цахилгаан	1,586,900.00	1,586,900.00	-	100.00
210302	Түлш, халаалт	21,600,000.00	21,600,000.00	-	100.00
210303	Цэвэр, бохир ус	3,044,700.00	3,013,112.00	31,588.00	98.96
2104	Хангамж, бараа материалын зардал	27,313,800.00	27,292,250.00	21,550.00	99.92
210401	Бичиг хэрэг	5,891,900.00	5,878,150.00	13,750.00	99.77
210402	Тээвэр, шатахуун	13,558,900.00	13,558,900.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,800,900.00	4,800,900.00	-	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	226,800.00	219,000.00	7,800.00	96.56
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,835,300.00	2,835,300.00	-	100.00
2105	Нормативт зардал	1,798,900.00	1,798,900.00	-	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,798,900.00	1,798,900.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,956,800.00	4,956,800.00	-	100.00
210604	Урсгал засвар	4,956,800.00	4,956,800.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	2,300,000.00	2,300,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	2,300,000.00	2,300,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	176,410,400.00	176,352,723.20	57,676.80	99.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	162,938,100.00	162,938,093.20	6.80	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	82,000.00	82,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	720,000.00	720,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,000.00	400,080.00	49,920.00	88.91
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	864,200.00	856,450.00	7,750.00	99.10
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	10,800,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	556,100.00	556,100.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,385,200.00	1,382,000.00	3,200.00	99.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,385,200.00	1,382,000.00	3,200.00	99.77
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,385,200.00	1,382,000.00	3,200.00	99.77
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	894,806,800.00	886,340,023.20	8,466,776.80	99.05
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	894,806,800.00	884,042,923.20	10,763,876.80	98.80
122005	Орон нутгийн төсвөөс	894,806,800.00	884,042,923.20	10,763,876.80	98.80
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	2,297,100.00	(2,297,100.00)	

**Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,297,100.00	(2,297,100.00)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	57.00	52.00	5.00	91.23
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	57.00	52.00	5.00	91.23
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	53.00	46.00	7.00	86.79
620003	Үйлчлэх ажилтан	3.00	5.00	(2.00)	166.67
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	57.00	52.00	5.00	91.23
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	35.00	30.00	5.00	85.71
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	22.00	22.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	900,911,416.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	900,911,416.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	900,911,416.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	900,911,416.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	900,911,416.40
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	175,263.60
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	175,263.60
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	901,086,680.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	901,086,680.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	700,193,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	200,893,680.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөх, анхан шатны баримтад нягтлан бодогчоос тавих хяналтыг сайжруулах, төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоолыг мөрдөх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 11 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Л.Оюун-Эрдэнэ, 2 дугаар гарын үсгийг С.Цэнд-Аюуш нар зурж, нярваар 2021 оны 1-8 дугаар сард Б.Батзолбоо, 9-12 дугаар сард З.Мягмардаш нар ажиллажээ.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар нь “Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах, аймгийн хэмжээний мал эмнэлгийн төр, хувийн хэвшлийн байгууллагыг нэгдсэн бодлогоор ханган, нийтийн эрүүл мэндийг хамгаалах” эрхэм зорилгын дор 2021 онд 894,806.8 мянган төгрөгийн төсөв батлагдаж 886,340.3 мянган төгрөгийг зарцуулан байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу 52 орон тоотой, үйл ажиллагаа явуулжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 20199.11.04-ний өдрийн А-385 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй, бусад хяналт шалгалтын байгууллагуудаас шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 1,897,821.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 28,467.31 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 18,503.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн зардлын 2,797,686.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 41,965.2 мянган төгрөг байгаа тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,451,888.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 694,021.1 мянган төгрөгөөр буюу 191.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	162,178.16	159,787.32	(2,390.84)
Авлага	-	1,100.00	1,100.00
Урьдчилгаа	-	7,200.00	7,200.00
Бараа материал	162,178.16	151,487.32	(10,690.84)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	595,689.70	1,292,101.61	696,411.90
Үндсэн хөрөнгө	857,993.98	1,721,687.59	863,693.61
Хуримтлагдсан элэгдэл	(262,304.28)	(429,585.98)	(167,281.71)
Нийт хөрөнгө	757,867.86	1,451,888.92	694,021.06
Өр төлбөр	60.66	-	(60.66)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	757,807.20	1,451,888.92	694,081.73
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	757,867.86	1,451,888.92	694,021.06

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны 2 харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Оны эхэнд авлагагүй, тайлант онд “Синапс” ХХК-аас үнэ төлбөргүй ирсэн хөрөнгөөс лабораторийн барилга баригдаж дууссаны дараа ашиглах хөрөнгийг аваагүй тул 1,100.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэсэн, төсвийн төлөвлөлт, зохицуулалт хийдэг “Open gov” программын 2022 оны төлбөрийг 2021 оны төсвөөс төлж, урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 151,487.3 мянган төгрөг болж өмнөх оноос 10,690.8 мянган төгрөгөөр буурсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 203,633.7 мянга, төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 828,197.7 мянган төгрөгийн бараа материалыг хүлээн авч, шатахууны хөнгөлөлтийн 586.0 мянган төгрөгийг бүртгэн, үйл ажиллагаандаа 1,017,098.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, газрын даргын 2021.06.29-ний өдрийн А/25, 2021.12.28-ний өдрийн А/66 дугаар тушаалаар 26,010.0 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг акталсан байна.

Оны эхэнд бүртгэлтэй 857,993.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр нэмж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар мал эмнэлгийн үйл ажиллагаа дэмжих чадавхжуулах ажлын хүрээнд нийт 863,693.6 мянган төгрөгийн 44 нэр төрлийн үндсэн хөрөнгө ирснийг хөрөнгөд бүртгэснээр оны эцэст 1,721,687.5 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ.

Өмнөх онд 2020.12.22-ны өдөр гүйлгээ хийсэн боловч гүйлгээ батлагдаагүй байхад санхүүжилт буцаан татсанаас шалтгаалж оны эцэст үйлдвэрчний эвлэлийн өглөгөөр 60.6 мянган төгрөг үлдэгдэлтэй гарсныг 2021 онд барагдуулж, оны эцэст өглөггүй ажиллажээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 694,081.7 мянган төгрөгөөр нэмэгдэж 1,397,211.3 мянган төгрөг болсон байна.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар улсын төсвөөс авах санхүүжилт өмнөх оноос 184,313.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 894,806.8 мянган төгрөг болсон нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх үйлчилгээний хөлс өмнөх онд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжиж байсныг 2021 онд байгууллагын үндсэн дансаар хийгдэж, төсөвт нэмэгдсэнтэй холбоотой байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар 2021 онд мал эмнэлгийн үйлчилгээний хөлсөнд анх 709,306.0 мянган төгрөг баталж, гүйцэтгэлээр 14,613.0 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгож, нийт 694,693.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн өөрчлөгдөөгүй бөгөөд тайлант жилийн үр дүн тайлангуудад зөв бүртгэгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2021.07.29-ний 140 дүгээр албан бичгээр 2021 оны төсвийн төлөвлөлтийг 943,147.1 мянган төгрөгөөр төлөвлөж, МЗЭГ-т хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70801, 70805 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэх төсвийн хуваарийг анх 747,675.2 мянган төгрөгөөр баталсан ба тайлант хугацаанд 2021 оны 7 дугаар сард 728,705.5 мянга, 9 дүгээр сард 732,305.5 мянга, 10 дугаар сард 888,842.7 мянга, оны эцэст 894,806.8 төгрөг болсон байна. Төсөв нэмэгдсэн нь малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйлчилгээний санхүүжилт 97,170.0 мянга, малын архаг халдварт өвчнөөс эрүүлжүүлэх үйлчилгээний санхүүжилт 57,367.2 мянга, нийт 154,537.2 мянган төгрөгийг Мал эмнэлгийн газраар дамжуулан олгосон нь нөлөөлсөн байна.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар тайлант онд улсын төсвөөс авахаар батлагдсан 894,806.8 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, 886,340.0 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 8,466.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Шинжилгээний орлогоор 2020 онд 2,000.0 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 2,080.1 мянган төгрөг орсон бол 2021 онд өөрийн орлогыг МЭЕГ-аас төлөвлөж өгөөгүй бөгөөд гүйцэтгэлээр 2,297.1 мянган төгрөгийг оны төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 901,086.6 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулж, оны эцэст 173.2 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

МЭЕГ-аас 2021 оны 12 дугаар сард төсөвт зохицуулалт хийж, мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд 10,800.0 мянган төгрөгийг тодотгон, тус зардлаас төсвийн төлөвлөлт, зохицуулалт хийдэг “Дата ланд технологи” ХХК-ийн “Open gov” программын 2022 оны төлбөрийг сарын 600.0 мянган төгрөгөөр тооцож, 7,200.0 мянган төгрөгийг 2021 оны төсвөөс төлж, урьдчилж төлсөн зардлаар бүртгэсэн байна.

Оны эхэнд бүртгэлтэй 857,993.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр нэмж улсын төсвөөс мал эмнэлгийн үйл ажиллагаа дэмжих чадавхжуулах ажлын хүрээнд нийт 863,693.6 мянган төгрөгийн 44 нэр төрлийн үндсэн хөрөнгө ирснийг хөрөнгөд бүртгэсэн байна.

Д/д	Орлогын төрөл	Мөнгөн дүн
1	Мал эмнэлгийн Ерөнхий газраас шүлхийн үйлчилгээний төлбөр	182,765,670
2	Орон нутгийн төсвөөс мал эмнэлгийн вакцинжуулалтын ажлын үйлчилгээний төлбөр	694,693,000
3	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораториос мал эмнэлгийн тандалт судалгааны ажлын зардал	18,128,010
4	Аймгийн Засаг даргын А/573 дугаар захирамжаар олгосон шүлхий өвчний зардал	5,500,000
	ДҮН	901,086,680

3.8 Аудитын гол асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичиг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зэрэгт тусгагдсан ажлуудыг хийж хэрэгжүүлэх хүрээнд 44 зорилтын хүрээнд 77 арга хэмжээ тусгагдаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг МЭЕГ-аас 84 хувиар үнэлжээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 1,911,397.4 мянган төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод мэдээлэхийг бүрэн мэдээлсэн, мэдээлбэл зохих 148 мэдээллээс 147 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хоцроож мэдээлсэн байна.

Хүснэгт 2. Шилэн дансанд байршуулсан мэдээлэл

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон
1	Бүтэн жил	8	8	7	1
2	Хагас жил	4	4	4	0
3	Улирал бүр	1	4	4	0
4	Сар бүр	3	36	36	0
5	Тухай бүр	8	96	96	0
	Нийт	24	148	147	1

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын шилэн данс

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, ТБОНӨХБАҮХАТХ болон Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын зарим

чиглэлийг хэрэгжүүлж ажиллаагүй нь холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэн зөвлөмжийг хүргүүлэв.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, 7 зөвлөмж өгсөн ба 2021 оны санхүүгийн тайланд аудитын хэрэгжилтийг дүгнэхэд малын тоо толгойг А дансаар баталгаажуулах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дээд шатны байгууллагаас тус байгууллагын орон тоонд жолооч, үйлчлэгчийн орон тоог батлаагүй, тайлант онд малын их эмчийн орон тоо дутагдалтайгаас 6 суманд тархвар зүйчийн орон тоо дутагдалтайгаас орон тоо дутуу тул жолооч, үйлчлэгчийг авч ажиллуулсан байгаа тул МЭЕГ цаашид орон тоог үндэслэлтэй төлөвлөх шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 16,520.3 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 2 зөрчилд 985.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгч, 15,535.3 мянган төгрөгийн зөрчилд байгууллагын удирдлагад 3 зөвлөмжийг хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын санхүүгийн тайланд залруулга хийгээгүй болно.

4.2 Албан шаардлага

1. Санхүүгийн тайланд газар бүртгэлгүй байхад газрын татвар төлсөн асуудлыг тодруулахад иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх 06401-2020/00421 дугаар гэрээг Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын дарга Л.Оюун-Эрдэнэ, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Жаргалмаатай байгуулж, 55612м талбай бүхий газрыг 15 жилийн хугацаатай эзэмшүүлсэн байхад холбогдох газар асуудлыг тавьж шийдвэрлүүлэн санхүүгийн тайланд үнэлж тусгаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2019 оны 271 дүгээр тушаалаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.8 дахь "Төрийн өмчит хуулийн этгээд нь газар эзэмших эрх шинээр авах саналаа тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан, холбогдох Газрын алба, сумын газрын даамалд хүсэлт гарган шийдвэрлүүлнэ. Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ." гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Санхүүгийн тайланд оны эхэнд бүртгэлтэй 985.0 мянган төгрөгийн мал амьтдын нас дэвшилтийн бүртгэлийг хийгээгүй, оны эцэст А дансаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж

баталгаажуулна”, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/395 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 5.3.7 дахь “Бараа материалын нэгдсэн тооллогыг хагас, бүтэн жилээр байгууллагын даргын тушаалаар томилогдсон тооллогын комиссын гишүүд хийж гүйцэтгэнэ. ...Тооллогыг хийж дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор хариуцсан нягтлан бодогч тооцоог бодож, тооллогын комисст хүлээлгэн өгөх ба комисс тооллогын үр дүнг удирдлагуудад танилцуулна” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Балансын данстай холбоотой асуудал*

1.1. *Илрүүлэлт:*

Бараа материалын дансанд хамт олны зураг, хувцас, хөргөгч, мотор, үсэг зэрэг хөрөнгүүд бүртгэлтэй байна.

1.2. ***Өгсөн зөвлөмж:*** Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/395 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн 5.3-т заасны дагуу хөрөнгийн ангиллыг зөв бүртгэх.

2. *Зардлын холбоотой асуудал*

2.1. *Илрүүлэлт:*

Бараа материалын зарцуулалтыг тулган шалгахад 2021 оны 01 дүгээр сард олгосон 675.1 мянган төгрөгийн боомын вакцин, 02 дугаар сард олгосон 186,8 мянган төгрөгийн аж ахуйн материалын анхан шатны баримтын бүрдэл дутуу, 8 дугаар сард олгосон МЭЕГ-аас олгосон 14,660.8 мянган төгрөгийн 17900 тун шүлхийн вакцины орлого, зарлагын тайланг нярав гаргаагүй, анхан шатны баримтыг санхүүгийн баримтад хавсаргаагүй, бичиг хэргийн материалын зарцуулалтын нярвын тайлан бүртгэлээс 12500 төгрөгөөр зөрүүтэй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын анхан шатны баримтын бүрдүүлэлт, хөтлөлтөд тавих нягтлан бодогчийн хяналтыг сайжруулах.

3. *Зардлын холбоотой асуудал*

3.1. *Илрүүлэлт:*

“Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1.8 дахь “Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах”, 1.9 дэх “Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулах” заалтуудыг мөрдөж ажиллаагүй байна.

3.2. ***Өгсөн зөвлөмж:*** Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар Засгийн Газраас гаргасан тогтоол, журмуудыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар	5	16,520.3	0	0.00	0	0	2	985.0	3	15,535.3

---оОо---